



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/20

Баянсайр

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4. дэх заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/91 дүгээр захирамжийн 4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Билгийн тооллын XVII дугаар жарны “Элдэв эрдэнэт” хэмээх модон могой жилийн Улаанбаатар хот дахь нутгийн иргэдийн сар шинийн нэгдсэн золголтыг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсугай.
2. Нутгийн зөвлөлд золголт зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Золголт зохион байгуулах зардалд 2 000 000 (хоёр сая) төгрөг, сум орон нутгийг сурталчлах зорилготой “Монгол малчин” сэтгүүлийн сар шинийн тусгай дугаарыг хэвлүүлэхэд 500 000 (таван зуун мянган) төгрөг, бусад зардалд 2 500 000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулан тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга (Б.Гэрэлмөнх), Нягтлан бодогч (Д.Анхтуяа) нарт үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогчид даалгасугай.

ДАРГА

С.ЭНХТӨР

642401229

Засаг даргын 2025 оны 03 дүгээр
сарын 11-ны өдрийн А/10 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

НЭГДСЭН ЗОЛГОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Мөнгөн дүн	Тайлбар
А	1	2	3
1	Золголтын зардал	2 000 000	
2	“Монгол малчин” сэтгүүлийн сар шинийн тусгай дугаар хэвлүүлэх зардал	500 000	
3	Золголтын бусад зардал (Идээ ундаа, ууц шүүс.) бусад дагалдах зардал	2 500 000	
	Дүн	5 000 000	

Засаг даргын оны..... дүгээр
сарынны өдрийн дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

С.Энхтөр

Сумын Засаг дарга

Гишүүдэд:

Д.Болормаа

Эрүүл мэндийн төвийн дарга

Г.Насанбаяр

Сургуулийн захирал

Х.Соёл-Эрдэнэ

Соёлын төвийн эрхлэгч

А.Бүжинлхам

Татварын Улсын байцаагч

Д.Должинсүрэн

Сан хариуцсан нягтлан бодогч

Т.Алтан-Очир

Соёлын төвийн хөгжмийн багш